

ГАЛУУТ СУМЫН “ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР”

Огноо: 2020.02.06

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР
ҮЙЛЧЛЭХ ХҮНСНИЙ ДЭЛГҮҮР СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Гэрээний нэр: Галуут сумын “хүнсний эрхийн бичгээр” үйлчлэх хүнсний
дэлгүүр сонгон шалгаруулах

Гэрээний дугаар: БХАГСЗДТГ/202001007

2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг даргын Тамгын газар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [Галуут сумын хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр]-ыг сонгон шалгаруулах тухай цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянган төгрөгийг цахим системээр дамжуулан төлсөн байх ёстой./

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 11 цаг 00 минут]-**аас өмнө өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор www.tender.gov.mn сайтад нэвтэрч цахимаар ирүүлнэ.

Үнийн саналын нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн [11 цаг 10 минут]-**д иргэний танхим 104 тоот өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Галуут сумын Засаг даргын Тамгын газар
(Санхүүгийн албаны өрөө 70446241,88549958,89596363 утсаар
холбогдоно уу?)

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа** 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт** 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл** 3.1 Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүн
 - (а). Үнийн санал
 - (б). Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь
 - (в). Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг
 - (г).Тусгай зөвшөөрөл шаардлагатай.
 - (д). Бэлтгэж ирүүлэх ТШӨХ-д заасан бусад материал.
4. **Тогтмол үнэ** 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзахгүй.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцлүүд** 5.1.Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж, хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох хай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусхаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг /түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт/ тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох	Шалгуур үзүүлэлт заалт
ТӨӨЗ 1.1.	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн тайлан ирүүлэх: 2018, 2019 оны санхүүгийн тайлан ирүүлэх шаардлагагүй сангийн яамны E- balance сайтад бүрэн шивэгдэж баталгаажсан байх / холбогдох мэдээллийг татаж харна/ 2. Энэхүү тендерийн бичиг баримтад тусгагдсан жишиг маягтын дагуу гаргаж баталгаажуулсан үнийн санал ирүүлэх. 3. Бараа нийлүүлэх хугацаа, график ирүүлэх. 4. Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар, үйл ажиллагааны чиглэл нь хүнсний дэлгүүрийн худалдаа эрхэлдэг байх. /тохирлын гэрчилгээ/ 5. Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монгол банк болон харилцагч банкнуудаас тодорхойлолт ирүүлэх. 6. Татварын байгууллагын тодорхойлолт шаардлагагүй цахим системээс татаж харна / Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх / 7. НДаатгалаас өр төлбөргүй тухай тодорхойлолт ирүүлэх / Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/ 8. Борлуулалтын хэмжээ: 2018-2019 оны борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн дундаж санал богож үнийн дүнгийн 40 хувиас багагүй байх. 9. Урьд өмнө ижил төстэй ажил гүйцэтгэгчээр сүүлийн 2 жил гүйцэтгэсэн бол захиалагчийн гэрээг дүгнэсэн дүгнэлтийг ирүүлэх.

	<p>Б.Хэрэв урьд өмнө ижил төстэй ажил гүйцэтгээгүй бол хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын дагуу өрсөлдөх тэгш боломжоор хангах.</p> <p>10. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ болон авах боломжит зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэй байх.</p> <p>11. Тендерт оролцогч нь малын гаралтай болон гурилан бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ.</p> <p>12. Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: Хүнсний эрхийн бичиг авах эрх үүссэн өрхийн гишүүн иргэдэд нийлүүлэх 10-н нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн нь хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан, хадгалалт хамгаалалтын стандартын горимын дагуу нөөцлөх, агуулах скалад, хөргүүр, тээврийн хэрэгсэл зэргийг өөрийн болон түрээсээр эзэмшдэг тухайгаа нотлох баримтаар ирүүлэх.</p> <p>13. Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Гэрээт хугацаанд нийлүүлэгдэх бүх бараа нь эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан зориулалтын сав баглаа, боодолтой, тээвэрлэлтийн үеийн гэмтлийг буцаах, солиулах, хугацаа хэтэрсэн тохиолдолд буцаах зэрэг тодорхойлолтыг албан бичгээр ирүүлэх.</p> <p>14. Татвар, төлбөр, хураамж төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно. Татвар, нийгмийн даатгал, банк, болон бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, ял шийтгэлтэй болох нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үгдэслэл болно.</p> <p>15. ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үгдэслэл болно.</p> <p>16. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн дагуу материалыг эмх цэгцтэй харагдахуйц тод бэлтгэж ирүүлэх.</p>
--	---

	<p>/Ирүүлсэн материалын харагдах байдал хангалтгүй тохиолдолд тухайн материалыг хангалтгүйд тооцож үнэлгээнд харгалзахгүй/</p> <p>Сахүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн хөрөнгөөр</p>
ТӨӨЗ 2.1.	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: [Галуут сумын Засаг даргын Тамгын газар /Санхүүгийн албаны өрөө, 70446241,88549958,89596363/ Утсаар холбогдоно]</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Цаг: 11 цаг 00 минутанд</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Давхар болон өрөөний дугаар: [Галуут сумын Засаг даргын Тамгын газар /Иргэний танхим 104 тоот өрөө/</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Цаг: [11 цаг 10 минут]</p>
ТӨӨЗ 2.3	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь: Багцгүй</p>

**ГУРАВ:ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭНД ТАВИГДАХ
ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Барааны тодорхойлолт стандарт: Галуут сумын Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр нь хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх бүх бараа, бүтээгдэхүүн нь Монгол Улсын хүнсний тухай хууль болон Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, холбогдох стандартад нийцсэнийг нотлох баримт хавсаргасан байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлийн найруулгыг ойлгоно.

2. Сав, баглаа боодол: Бараа тус бүр эрүүл ахуйн стадарт шаардлага хангасан зориулалтын сав баглаа боодолтой байх. Мах махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн болон хүнсний ногоо, жимс жимсгэнэ, гурилан бүтээгдэхүүний баталгаат хугацааны эхлэх, дуусах огноо тодорхой заасан байна. Тээвэрлэлтийн үеийн гэмтлийг буцаах, солиулах, хугацаа хэтэрсэн тохиолдолд буцаах.

3. Бараа хүргэх газар: Үйлчилгээ үзүүлэх дэлгүүртэй

4. Сонгон шалгаруулах барааны жагсаалт: Жилийн нийт дүнгээр

**ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГЭЭР ҮЙЛЧЛЭХ ДЭЛГҮҮРЭЭС ИРҮҮЛЭХ
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТОДОРХОЙЛОЛТ**

Жич: Тендерт оролцогч нь маягтаар ирүүлсэх үнийн саналдаа дээрхи барааны нэгжийн болон нийт үнийн дүнг тодорхойлон ирүүлнэ.

№	Төрөл	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Мах, махан бүтээгдэхүүн	Тэмээний мах	кг	Эрүүл ахуйн шаардлага хангасан, хадгалалтын горим алдагдаагүй, шинэ байх. /Хиам болон лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн орохгүй/
		Адууны мах	кг	
		Үхрийн мах	кг	
		Хонины мах	кг	
		Ямааны мах	кг	
		Дайвар бүтээгдэхүүн	Кг,ш	Толгой цувдай эрүүл ахуйн болон хадгалалт, тээвэрлэлтийн шаардлага хангасан, шинэ байх

2	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Шингэн сүү	л	Эрүүл ахуйн шаардлага хангасан, шингэн сүү байх, Дотоодын үйлдвэрийн болон малын гаралтай байх.
		Хуурай сүү	кг	
		Тараг	л	
		Аарц	кг	
3	Гурил, гурилан бүтээгдэхүүн	Дээд гурил	кг	Эх орны үйлдвэрийн, хадгалалтын горим алдагдаагүй, хугацаа дуусаагүй эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай шинэ бүтээгдэхүүн байна. /Бялуу, кекс хамаарахгүй/
		Гурил 1 дүгээр	кг	
		Гурил 2 дугаар	кг	
		Гурилан боов, боорцог	Кг, уут	
		Бүх төрлийн гоймон	Кг, ш	
4	Хүнсний ногоо	Төмс хүнсний ногоо	кг	Монгол эх орны хөрсөнд ургасан, эрүүл ахуйн болон чанарын шаардлага хангасан шинэ чанартай ногоо байна. /Лаазалсан, даршилсан дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй/
5	Ургамлын тос	Ургамлын тос	л	Эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн байх
6	Цөцгийн тос	Цөцгийн тос	Уут, кг	Эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн байх
7	Жимс жимсгэнэ	Жимс, жимсгэнэ	кг	Шинжилгээний бичигтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, шинэ, хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй
8	Будаа	Цагаан будаа	кг	Шинжилгээний бичигтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, шинэ, хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй
		Шар будаа	кг	
		Бор будаа	кг	
9	Элсэн чихэр	Элсэн чихэр	кг	Шинжилгээний бичигтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, шинэ, хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй
10	өндөг	өндөг	ш	Шинжилгээний бичигтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан, шинэ, хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй

Тайлбар: 1.Мах дайвар бүтээгдэхүүнд худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүх төрлийн мал, амьтны мах, малын гэдэс дотор, толгой шийр орно. Хиам болон лаазалсан, дахин боловсруулсан махан бүтээгдэхүүн хамаарахгүй.

2.Сүү, сүүн бүтээгдэхүүн гэдэгт хуурай болон шингэн сүү, тараг, аарц, хамаарна.

3.Гурилан бүтээгдэхүүнд бялуу, кекс хамаарахгүй.

4. Төмс, хүнсний ногоо гэдэгт дарсан ногоо буюу лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй. Хүнсний ногоонууд нь монголын хөрсөнд тарьж ургуулсан байх.

5. Будаа гэдэгт бүх төрлийн будаа, хүүхдийн будаа үр тариа, шар буурцгийн гаралтай бүтээгдэхүүн хамаарна.

6. Жимс, жимсгэнэ гэдэгт компот, жимсний чанамал, хатаасан жимс хамаарахгүй.

Мөн үнийн саналыг ирүүлэхдээ хүнсний бүтээгдэхүүний төрлөөр нь ангилж олон сонголттой бичиж ирүүлэх.

Жишээ нь: 1-р гурил, 2-р гурил тус бүрийн үнэ жижиглэнгээр, уутаар гэх мэт ангилж, олон сонголттой бичиж ирүүлэх.

Мах: Хонины мах, үхрийн мах, ямааны мах, адууны мах гэх мэт

Сүү: Хуурай сүү шингэн сүү

Жимс, жимсгэнэ: Алим, помидор, мандарин, усан үзэм, гэх мэтээр ангилж тус бүрийн үнийг бичиж ирүүлнэ.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1.

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[Огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийн тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн
1	2	3	4	5	6
Тендерийн нийт үнэ					

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаар хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг /утас/ факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3				
Бусад				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах | зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл /ГТН/-д эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1 | патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээх гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог |
| 4. Бараа хүргэх тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа /0/ жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэл хүлээн авснаас хойш /14/ хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтонд заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |

хуваарь

- 9. Алданги оногдуулах**
- 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа,
гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээ-
-гээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг барагдуулна.

11. Маргааныг

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар

12

шийдвэрлэх

тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. **Шалгах болон турших /ГЕН-1/**

1.1. Нийлүүлэгдэх барааг Ерөнхий боловсролын сургуулийн холбогдох ажилтан чанар байдлыг шалган тоолж зарлагын баримт нэхэмжлэх, санхүүгийн баримтаар хүлээн авч баталгаажуулна.
2. **Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт /ГЕН-2/**

2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
1. Нийлүүлэгчийн барааны нэр, тоо хэмжээ, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь
2. Барааг хүргэсэн тухай баримт болон тээврийн баримт
3. Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ
4. Барааны гарал үүслийн гэрчилгээ.
Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. **Баталгаат засвар /ГЕН-5/**

5.1. Баталгаат засварын тусгай шаардлага
(Гэрээний ерөнхий нөхцлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана)
4. **Төбөр /ГЕН-7/**

7.1 Гэрээний ерөнхий нөхцлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнийн дүнгийн **/100/** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. **Алданги оногдуулах /ГЕН-9/**

9.1. Алданги оногдуулах хувь: **/0,5 хувь/**
Алдангийн нийт дүн: / **1 хувь/**
0

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)_____
(Тамга, тэмдэг)_____
(Гарын үсэг)_____
(Гарын үсэг)_____
(Албан тушаал)_____
(Албан тушаал)**[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт гэрээний дугаар]

.....хот/аймаг

Нэг талаас **[Захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид ‘нийлүүлэгч’ гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож

_____оны _____сарын _____–ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1.Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний

ач холбогдол оршино.

2 Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]** –г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэд болно.

3 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4 Нийлүүлэгч нь _____нэр төрлийн барааг _____оны _____дугаар сарын _____-наас _____оны _____дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5.Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно цаашид “гэрээний баримт бичиг” гэх Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

Бусад шаардлагатай баримт бичиг

Үнийн санал

Гэрээний тусгай нөхцөл

Гэрээний ерөнхий нөхцөл

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь

Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгийн буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны дансны нэр, дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]